

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2020.01.24-2020.02.25/

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сумын Засаг даргын зөвлөлийн хурлыг 2020 оны 01-р сарын 23-ны өдөр зохион байгуулж аймгийн “Аварга малчин”-аар Б.Отгонбаатарыг шалгаруулж материалыг аймгийн Засаг даргад хүргүүлсэнд болзолыг ханган шалгарсан. Мөн сумын “Аварга малчин” -аар Т.Батболд, Т.Мягмар, Ш.Бадамханд нарыг шалгаруулсан.


Сумын онцгой комисс 2020 оны 01-р сарын 27-ны өдөр хуралдаж Коронавирусийн халдвараас иргэд олон нийтийг хамгаалах, эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах зорилгоор суманд үйл ажиллагаа явуулдаг биллъярд, мөсөн коток, РС тоглоомын газрын үйл ажиллагааг түр зогсоож, өдөр бүр эргүүл хийх хуваарь гарган бага насны хүүхдийг олон нийтийн газраар явуулахгүй байх анхааруулгыг эцэг, эхчүүдэд өгч ажиллаж байна.

Говьсүмбэр аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран амны хөндийн үзлэг, эмчилгээг 2020 оны 01 сарын 20-ны өдрөөс 7 хоногийн хугацаанд зохион байгуулж амны хөндийн үзлэгт нийт 1-2 дугаар ангийн 6 бүлгийн 161 сурагч хамрагдаж, 126 сурагч өвчлөлтэй буюу шүдний өвчлөлийн тархалт 78,6%-тай байна. Үүнээс эмчилгээнд хамрагдах шаардлагатай 105 сурагчийг эмчилгээнд хамруулсан.



Сумын Онцгой комиссын хурлыг 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулж шинэ корона вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх аймгийн Засаг даргын 2020 оны А/56 дугаар захирамжийн дагуу “Сумын Шуурхай штаб”-ыг сумын Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/23 дугаар Захирамжаар байгуулан онцгой комиссын гишүүдийг 2020 оны 02-р сарын 14-өөс 03-р сарын 02-ны өдрийг хүртэл 07:00-21:00 цагийн хооронд жижүүр хийх хуваарийг гарган ажиллаж

байна. Мөн суманд үйл ажиллагаа явуулж буй баар, караоке зэрэг согтууруулах ундаагаар үйлчилдэг газруудын үйл ажиллагааг 02-р сарын 14-ний өрдөөс 03-р сарын 02-ны өдөр хүртэл түр зогсоож, хүнсний дэлгүүр, зоогийн газар зэрэг согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилдэг газруудын цагийн хуваарийг өглөөний 10:00-аас оройн 20:00 цаг хүртэл ажиллах чиг үүрэг өгч сумын цагдаагийн хэсэг хяналт тавин ажиллаж байна.



Сумын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж албан байгууллагуудын мэдээлэлтэй танилцан байгууллагуудын удирдлагуудад холбогдох чиглэлийн дагуу хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, тайланг хуулийн хугацаанд гаргаж баталгаажуулан аймгийн Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлсэн.

Сумын нийт төрийн албан хаагчдын Монгол бичгийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Монгол бичгийн сургалтыг 2-р сараас 5-р сар хүртэл зохион байгуулах хуваарийг гарган ажиллаж байна.

Байгууллагын дотоод эрх зүйн сургалтыг 3 удаа зохион байгуулж 53 албан хаагч хамрагдсан байна.



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

3-Р СУРГУУЛЬ :

Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор үдийн цайны зардал 900 төгрөг болж өөрчлөгдсөнтэй холбогдуулж комиссын гишүүд 2020 оны 01-р сарын 21-ний өдөр хуралдан “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэгч “Сүмбэр шүтээн” ХХК-тай гэрээг шинээр байгуулж амт, илчлэг чанарт анхааран 7 хоногт махан хоол 3 удаа, жимс жимсгэнэ гурил гурилан бүтээгдэхүүн 1 удаа, цагаан хоол 1 удаа тус тус өгөхөөр зөвлөгөөг өгч ажилласан.



Сумын ерөнхий боловсролын багш, ажилтны хөдөлгөөнт эргүүлийн хуваарийг гарган хуваарийн дагуу гудамж талбай, мөсөн гулгуур, РС тоглоомын газар, болон дэлгүүрээр бага насны хүүхэд үйлчлүүлж буй 53 тохиолдолд эцэг эхийн утас руу залгаж анхааруулга өгч эцэг, эх суралцагчдад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар 100 гаруй ухуулга сурталчилгаа, зөвлөмжийг тарааж ажилласан байна.




БСШУЯ, Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй дотуур байрны суралцагчдын амьдрах орчин

нөхцлийг сайжруулах “Хүүхэд хөгжлийн өргөө миний гэр” төсөл, 1 дүгээр ангийн сурагчдын дасан зохицох чадварыг хөгжүүлэх “Тоглонгоо суралцъя” төслүүдийн анги кабинетын тохижилт, засварыг бүрэн хийж дуусган сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бэлэн болгоод байна.



Үндэсний хэмжээнд зохион байгуулагдах теле хичээлийн хуваарь болон мэргэжлийн хичээлийн даалгаврыг анги удирдсан багш нар эцэг эх суралцагчдад цахим хэлбэрээр хүргэн хяналт тавин ажиллаж байна.

Малчин өрхийн сурагчдын судалгааг гаргаж, нийт 75 сурагчид хорио цээрийн дэглэмийн үед хийх хичээлийн даалгаврыг гаргаж өглөө.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

Эрүүл мэндийн төвд 26 өвчтөн хэвтэж үүнээс 17-н хүүхэд хэвтэн эмчлүүлж байна.

Эмнэлгийн үйлчилгээ нь:

- Амбулаторийн үзлэг – 345 үүнээс томуу-51

- Урьдчилан сэргийлэх –95

- Дуудлага- 140

МУЗГ-ын тогтоолын дагуу 2020 оны 01-р сарын 27-ноос хязгаарлалтын дэглэм тогтоож, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн анги танхимын ариутгал халдваргүйтгэлийг хийж, албан хаагчдыг витаминжуулсан.



Коронавирусийн халдварын сэжигтэй тохиолдлын үед ажиллах бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд Эрүүл мэндийн төвийн даргын А/04 тушаалаар сэжигтэй тохиолдолд ажиллах багийг томилон үүрэгжүүлж, тусгаарлах өрөөний бэлэн байдал, ажиллах орох, гарах схемийг боловсруулсан.

Эрүүл мэндийн төвийн даргын А/03 дугаар тушаалаар уртасгасан цагаар ажиллах хуваарийг гарган ажиллаж, 0-5 настай хүүхдийг гэрээр үзлэгт хамруулан гэрийн эргэлтийг хийн ажиллаж байна.

Иргэдийг коронавирсийн талаарх буруу ташаа мэдээлэлд автахаас урьдчилан сэргийлж үнэн зөв мэдээллийг түргэн шуурхай хүргэж, коронавирсээс урьдчилан сэргийлэх мэдээллийг албан байгууллагуудад албан тоотоор хүргүүлэн ажилласан.

Коронавирсийн халдвараас урьдчилан сэргийлэх 5 төрлийн гарын авлагыг мэдээллийн самбар болон цахимаар, үйлчилгээний газраар үйлчлүүлж буй иргэдэд олгож, орон сууцнуудын орц бүрийн хаалган дээр байршуулаад байна. Мөн үйлчилгээний байгууллагын 116 ажилтанд эрүүл мэндийн боловсрол олгож ажилласан.

Хэвтэн эмчлүүлж буй иргэдэд гараа зөв угаах дараалал, халдвараас өөрийгөө хамгаалах аргад сургаж байна.



Малчдын эрүүл мэндийг дэмжих ажлын хүрээнд 2020 оны 02 сарын 11, 12-ны өдрүүдэд хөдөөгийн багийн 28 малчин өрхийн 84 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан коронавирусаас урьдчилан сэргийлэх зөвлөгөө зөвлөмжийг өгч ажиллалаа.



Швед Улсад ажиллаж амьдардаг Шивээговь сумын иргэн Ш.Ононбаяр 02 сарын 10-ны өдөр 500ш амны хаалтыг хандивлаж, 300ш амны хаалтыг эмнэлгийн дотоод нөөцөд, 200ш амны хаалтыг хөдөөгийн малчин иргэд болон зорилтот бүлгийн иргэдэд тараасан. Мөн суманд амны хаалт оёж зарж буй оёдолчин З.Билэгбаярт амны хаалтыг стандартын дагуу оёх зөвлөмжийг өгч ажилласан.



Сумын Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд “Шинжилгээ авах лабораторын үйл ажиллагаа”, “Коронавирусаас

урьдчилан сэргийлэх” сэдвүүдээр дотоод сургалтыг зохион байгуулсан.

УЛСЫН БҮРТГЭЛ

Иргэний бүртгэлийн үйлчилгээг 58 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 7 иргэнг бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийлгэсэн.

2-р сард газраа анх удаа өмчилж авч байгаа 8 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн гэрчилгээг олгоод байна. Нийт 36 иргэн газар өмчлөлийн гэрчилгээг аймаг орохгүйгээр сумаасаа аваад байна. Ингэснээр иргэд цаг хугацаа, эдийн засаг, санхүүгийн 288000 төгрөгийн хэмнэлтийг эдлээд байна.

Иргэдээс энэ сард 36 өргөдөл хүлээн авсныг хугацаанд нь шийдвэрлэсэн.

УИХ-ын сонгууль болохтой холбогдуулан 2020 оны 02 дугаар сарын 01-нээс эхлэн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоож, шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтэр болон маягтуудыг аймгийн УБХ-ийн хяналтын улсын байцаагчид акт үйлдэн хүлээлгэн өгөөд байна.

Иргэний гэр бүл байдлын статистик мэдээ тайлан болон Иргэний бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үнэт цаасны тайлан, үнэт цаасны орлогын тайлан зэргийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2020 ОНЫ 02 САРЫН МЭДЭЭ

Шивээговь

	м/д	Бүгд	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Төрсөн хүүхэд	1	16				16	7	9
Төрсөн эх	2	16				16		16
Бүртгүүлсэн гэр бүл	3	1				1	1	1
Нас баралт	4	5				5	5	-
Цуцалсан гэр бүл	5	1				1	1	1
Үрчлэгдсэн хүүхэд	6	-				-	-	-
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	7	16				16	8	8

Аймаг, нийслэл рүү шилжин явсан	8	-				-	-	-
---------------------------------	---	---	--	--	--	---	---	---

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОРСОН ОРЛОГО

2020.02.20.

д/д	Үйлчилгээний нэр төрөл	2020 оны 02-р сар					Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 300200022101 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд			
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
1	Нийслэлээс шилжин ирсэн	5000	3	15000	1000	3	3000	
2	Өөр аймгаас шилжин ирсэн	2500	7	17500	1000	7	7000	
3	Аймаг доторх шилжилт хөдөлгөөн	1500	12	18000	1000	12	12000	
4.	Гэрлэлтийн бүртгэл	2500	1	2500				
Дүн		53000			22000			
д/д	Үйлчилгээний нэр төрөл	2020 оны 02-р сар					Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 300200022130 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд			
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
5.	Иргэний үнэмлэх	15000	7	105000	3300	8	23100	
Дүн		105000			23100			
Нийлбэр дүн		158000			45100			
Нийт орлогын дүн		203100						

ХӨДӨӨ АЖ АХУЙ

Сумын бэлчээрийн даац хүрэлцэхгүй байгаатай холбогдуулан Засаг даргаар ахлуулсан бүрэлдэхүүн гадны аймаг сумаас отроор яваа өрхүүдээр орж бэлчээр чөлөөлөх мэдэгдэл өгч, малын халдварт болон гоц халдвар өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд хамрагдсан байдал ба малын эрүүл мэндэд хяналт хийж ажилласан.

Манай сумаас гадны аймаг, сумдад отроор 27 өрхийн 7464 толгой мал оторлож байна. Манай суманд гадны аймаг, сумдын 10 өрхийн 6857 толгой мал отроор орж ирсэн байна.

Отгор нүүдлийн судалгаа
2020.01.30

№	Аймаг, сумын нэр	Отгор нүүдлээр ирсэн малчин өрх, малын төрөл, тоо					Отгор нүүдлээр бусад өймаг сум руу явсан малчин өрх, малын төрөл, тоо						
		Аль өймаг сумд ирсэн	Малчин өрхийн тоо	Малын төрөл				Аль өймаг сум руу явсан	Малчин өрхийн тоо	Малын төрөл			
				Үхэр	Хонь	Ямаа	Адуу			Тэмээ	үхэр	хонь	ямаа
1	Говьсүмбэр Сумбар	2	12	1105	419	160	Дорнод Халинбаяр	2	235	520	780	74	
2	Дундговь Эрдэнэдалай	2	19	505	517	5	Дорноговь Дэлгэнжаргалан	4	7	97	60	28	
3	Дундговь Луус	2	27	694	724		Говьсүмбэр Сумбар	10	130	1029	1047	31	
4	Дундговь Говь Утгаал	2		1250	850	6	Хантуй Дархан	1	4		20	23	
5	Дундговь Сайн Цэцэглэн	2	37	117	410		Дорноговь Иххэт	2	7	251	263	45	
6							Дундговь Цагаанцацгар	1	6	100	160	5	
							Дорноговь Айраг	1	14	112	114	28	
							Дундговь Сандарин	2	62	1016	396	28	
							Дундговь Баянжаргалан	3	9	327	324	40	4
							Дундговь Дэлгэрцогт	1		27	30	4	2
	Нийт	10	95	3671	2920	171	Нийт	27	474	3479	3194	311	6



Сумын Засаг даргын 2020 оны 01-р сарын 13-ны өдрийн А/03 дугаар “Сумын төвийн мал бүхий иргэдийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Захирамжийг сумын төвийн мал бүхий иргэдэд хүргэж сумын төвд мал оруулахгүй байх талаар үүрэг өгч ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах, Коронавирусээс урьдчилан сэргийлэх, далайн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн худалдан борлуулж байгаа эсэх, хүнсний стандартыг мөрдөн ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих ажлыг 2020 оны 2 дугаар сарын 6, 7-ны өдрүүдэд зохион байгуулж сумын нутаг дэвсгэрт худалдаа үйлчилгээ эрхэлж буй 14 ААНБ-уудыг хамруулж нийт 293 938 төгрөгийн үнэ бүхий хугацаа хэтэрсэн болон хаяг шошго нь тодорхойгүй бараа бүтээгдэхүүнийг хураан авч устгалд оруулсан.



Улсын Мал Эмнэлэг Ариун Цэврийн Төв Лабораторийн шинжилгээний хариуны дагуу сумын аюулгүйн нөөцөд байгаа өвсийг устгах дүгнэлт гаргаж 741 боодол өвс устгалын ажлыг 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан.



Аймгийн Мал эмнэлгийн газрын даргын баталсан “Аймгийн хэмжээний гахай, тахиатай өрхүүдэд ариутгал халдваргүйтгэл хийх ажлын удирдамж”-ын дагуу ариутгал халдваргүйтгэлийн ажлыг 2020 оны 02 дугаар сарын 19-ны өдөр суманд тахиа, гахай тэжээдэг 4 өрхийн 108,75м² талбай бүхий 5 байрнд технологийн дагуу хийж гүйцэтгэсэн. Мөн тус өрхүүдэд “Мал амьтны гоц халдварт өвчний болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх” зөвлөмжийг хүргэж, мал эмнэлгийн гэрчилгээг авч хэрэглэх талаар мэдээлэл өгч, халдваргүйжүүлэлт хийсэн акт бичиж өгсөн.




Төлийн мэдээ: 02-р сарын 21-ний өдрийн байдлаар 313 мал төллөж 313 төл бойжсон байна. Үүнд: үнээ 4, хонь 131, ямаа 178 төллөсөн байна. Том малын зүй бус хорогдол 5 байна.

БАГИЙН ЗАСАГ ДАРГА НАР

Аймгийн Засаг даргын 2019 оны А/426 дугаар захирамжийн дагуу цэргийн шинэчилсэн бүртгэлийн ажлыг 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 02 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулж сумын хэмжээнд 75,8%-тай бүртгэлийн ажлыг хийж гүйцэтгэн тайлан, мэдээг хугацаанд нь хүргүүлсэн.

Цэргийн шинэчилсэн бүртгэлтэй холбоотой зар мэдээллийг цахимаар болон цаасан хэлбэрээр зарын самбарууд, фэйсбүүк хуудасаар олон нийтэд хүргэж ажилласан. Мөн мессэж үйлчилгээгээр 2 удаа цэргийн шинэчилсэн бүртгэлийн хугацаа болон Зөрчлийн тухай хуулиар авах арга хэмжээний талаарх мэдээллийг давхардсан тоогоор 1107 иргэнд хүргэсэн.



ХӨДӨЛМӨР ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулан 6 иргэний өргөдлийг шийдвэрлэн тэтгэвэр тэтгэмжид, 1 өрхийг, өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд хамруулаад байна. Үүнд:

- ❖ Асаргааны мөнгөн тэтгэмжид – 3 иргэн
- ❖ Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид – 3 иргэн
- ❖ Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд – 1 өрх
- ❖ Асаргааны мөнгөн тэтгэмж – 5 иргэнд 305140 төгрөг
- ❖ Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж – 2 хүүхдэд
- ❖ Халаалтын хөнгөлөлт – 1 иргэн
- ❖ 0-3 насны хүүхдээ асарч байгаа - 8 эх
- ❖ Жирэмсэн эхийн тэтгэмж – 2 иргэн
- ❖ Ахмад настан тэргэнцэр -1 иргэн
- ❖ Ахмад настан хиймэл шүд хийлгэсэн – 1 иргэн
- ❖ Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэрийн зөрүү - 10 иргэн

2020 оны 2-р сарын 10-ны өдрөөс эхлэн Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу “Эхийн алдарт 1, 2-р одон”-той нийт 222 эхэд 29.500.000 төгрөгийг олгосон. Үүнд:

- ❖ Эхийн алдарт 1-р одонтой 71 эхэд 14.200.000 төгрөг

❖ Эхийн алдарт 2-р одонтой 153 эхэд 15.300.000 төгрөг нийт

2020 оны 2-р сарын 10-ны өдрөөс эхлэн Ахмад настаны тухай хуулийн дагуу “Насны хишиг”-ийн тэтгэмж авах иргэдийн олголтын жагсаалтыг бэлтгэж арилжааны банкаар дамжуулан 111 ахмад настанд 8.280.0000 төгрөгийн олгосон. Үүнд:

❖ 65-69 насны 48 ахмад настанд 2.400.000 төгрөг

❖ 70-79 насны 51 ахмад настанд 4.080.000 төгрөг

❖ 80-89 насны 12 ахмад настанд 1.800.000 төгрөг

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01-р сарын 22-ны өдрийн 25 тоот тогтоолоор Нийгмийн халамжийн тэтгэвэр 188000 төгрөг, ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэн асарч байгаа иргэнд олгох асаргааны мөнгөн тэтгэмж 84500 төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэнд олгох асаргааны мөнгөн тэтгэмж 123100 төгрөг болж нэмэгдсэнтэй холбогдуулан тэтгэвэр тэтгэмжийн бүх хувийн хэрэгт бичилтийг хийсэн.



Дэлхийн зөн – Бор-Өндөр 1 төслөөс сумын зорилтод бүлгийн 15 өрхөд 2020 оны 02-р сарын 08-ны өдөр хүнсний тусламжийн зүйлийг хүлээн авч 11 өрхөд тараах ажлыг зохион байгуулсан. Мөн Дэлхийн зөн олон улсын байгууллагаас бүтэн өнчин 4 хүүхдэд хувцас, хүнсний бүтээгдэхүүний дэмжлэг үзүүлсэн.

НИЙГМИЙН БОДЛОГО



Сумын харьяалалгүй ахмад настнуудыг аж ахуйн нэгж байгууллагад харьяалуулах ажлыг зохион байгуулж Сумын хэмжээнд нийт 245 ахмад настнаас 225 ахмад настан буюу 91,8 хувийг суманд үйл ажиллагаа явуулдаг 45 аж ахуйн нэгж, байгууллагад харьяалуулж, харьяалалгүй 20 ахмад настныг аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт хүргүүлж хүндэтгэл үзүүлсэн.

Сумын Хамтарсан багийн хурлыг 2020 оны 02 сарын 03-ны өдөр зарлан хуралдуулж, Хамтарсан багийн 2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталж, 1 кейсийн асуудлыг хэлэлцэн төлөвлөгөө гаргалаа.


Бүх нийтийн их цэвэрлэгээг 2020 оны 02-р сарын 07-ны өдөр зохион байгуулж давхардсан тоогоор 14 аж ахуйн нэгж байгууллагын 65 иргэн 2 га талбайн 1,5 тн хог хаягдлыг түүж цэвэрлэн төвлөрсөн хогийн цэгт ачиж зайлуулсан.



ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ САН

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хогны машин худалдан авах цахит тендерийг 2020 оны 01-р сарын 28-ны өдөр зарлаж, 03-р сарын 02-ны өдөр нээнэ. Төв талбайд усан оргилуур байгуулах ажлын үнэлгээний хороо хуралдаж тендерийг зарлахаар ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу 2021 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний саналыг сумын нийт 563 иргэдээс цаасаар авч, 73 иргэнээс цахимаар аваад байна.



байна.

“Зорилтот бүлгийн иргэдэд хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлэх хүнсний дэлгүүрийг сонгон шалгаруулах ажиллагааг хуулийн дагуу цахимаар зохион байгуулж, 2020 оны 02 сарын 11-ний өдөр тендерийг нээж 2 компани үнийн санал ирүүлснээс “Оюу шивээ арвижих” ХХК-ийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлээд

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР